

2019 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН




МЦХ ХК
2019.07.18

- 2019 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны гүйцэтгэл
- Хувьцаа эзэмшигчдийн хурал
- Төлөөлөн удирдах зөвлөл
- Ногдол ашгийн тухай

Өндөр хурдны интернэт

Албан байгууллагын өндөр хурдны интернэт хэрэглэгчийн зах зээлийг нэмэгдүүлэх, орлогыг өсгөх ажлын хүрээнд Улаанбаатар хотын шилэн кабелийн хэрэглэгч рүү чиглэсэн өндөр хурдны интернэтийн үйлчилгээний урамшуулалт хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүллээ. Хөтөлбөрийн хүрээнд шинэ хэрэглэгчийн тоо нэмэгдсэн үр дүнтэй байна.



National Катв-н цар хүрээг нэмэгдүүлэх

National катв-н цар хүрээг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Баян-Өлгий аймгийн 4 сум, Баянхонгор, Ховд, Сүхбаатар, Багануур аймгуудад тоон телевизийн үйлчилгээг хүргэхээр бэлтгэл ажлыг хангаж хэрэглэгч хүлээн авч эхлээд байна. Шинээр катв-н үйлчилгээ орж байгаа аймгуудад тусгайлан урамшууллын хөтөлбөр хэрэгжүүлж ажиллаж байна.





Алба хэрэглэгч

Өндөр хурдны интернэт хэрэглэгч болон бодит хурдны интернэт хэрэглэгчийн тоог нэмэгдүүлэхээр ажиллаж нийт 450 гаруй албан байгууллагуудад бүтээгдэхүүн үйлчилгээгээ танилцуулан, борлуулалт хийж, 100 гаруй байгууллагатай гэрээ байгуулан, хамтын ажиллагаагаа өргөтгөлөө.



Орон нутагт чиглэсэн маркетинг

Орон нутагт чиглэсэн онцлог маркетинг хийх зорилтын хүрээнд 4 аймагт урамшууллын хөтөлбөрийг хэрэгжүүлсэнээр суурин утас, интернэт, КаТВ-ийн хэрэглэгчийн тоо нэмэгдлээ. Мөн 8 аймагт урамшууллын хөтөлбөр хэрэгжих шатандаа явж байна



Орон нутагт салбар нэгжтэй байгууллагыг хэрэглэгч болгон элсүүлэх

Орон нутагт салбар нэгжтэй төрийн болон бизнесийн албан байгууллагуудыг хэрэглэгчээр элсүүлж, хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэх ажлын хүрээнд:

- Монгол даатгал ХХК-ийн 23 салбарт интернэтийн үйлчилгээ;
- Нийгмийн Даатгалын Ерөнхий Газрын 30 салбарт интернэтийн үйлчилгээг тус тус хүргэж байна.

Үйлчилгээний стандартын хэрэгжилт, хэвшүүлэлт

УБ хотын 4 БХГ болон 23 АДХГ-ын үйлчилгээ, борлуулалтын ажилчдаас дараах чиглэлд тандалт судалгаа хийсэн.


- Стандартын дагуу хэрэглэгчтэй мэндлэх, төгсгөх – 64%
- Хэрэглэгчийн анхааралтай сонсох, хэрэглэгчийн лавлагааг ойлгохыг хичээх – 90%
- Хүндэтгэлтэй харьцах байдал – 89%
- Дуу хоолойн хандлага /сул, залхсан, нойрмог, ууртай байх г.м/ - 90%
- Хэрэглэгчийн яриаг ойлгож ярианд дэмжлэг үзүүлсэн байдал (тодруулж асуух, асуултаа мэдэхгүй байгаа тохиолдолд яриаг дэмжих) – 84%
- Үндсэн үйлчилгээгээ үзүүлж буй байдал: Асуусан асуултанд хурдан шуурхай хангалттай бүрэн хариу өгч чадсан эсэх - 55%-н үр дүнтэй байна.

Нийтэд нь үйлчилгээ болон борлуулалтын ажилчдыг дүгнэвэл 63%-ийн гүйцэтгэлтэй байна.

Хэрэглэгчийн тандалт судалгаа /Үйлчилгээний чанар судлах чиглэлд/

2019 оны II-р тандалт судалгаанд АДХГ болон БХГ –уудын “цуцалсан”, “шинэ”, “идэвхгүй” төлөвт байгаа хэрэглэгчийг хамруулсан байна.

Судалгааны үр дүнд тулгуурлан үйл ажиллагааны чанарыг сайжруулах чиглэлд анхаарч ажиллаж байна.



GPON, шилэн кабелийн сүлжээний өргөтгөл

Хэрэглэгчид өндөр хурдны интернэтийн үйлчилгээ хүргэх, найдвартай байдлыг хангах ажлын хүрээнд шилэн кабелийн сүлжээний өргөтгөл хийхээр ЗБХГ-ын NGN45, MSAN351, MSAN352, ББХГ-ын MSAN63, MSAN68, MSAN361, MSAN362 шаадлагатай чиглэлүүдэд зураг төслийг боловсруулан өргөтгөлийн ажил хийгдэж байна.

УБ хотын электрон телефон станцуудыг шинэчлэх

Уламжлалт электрон телефон станц ЭАТС32-ыг IP суурьтай NGN станцаар сольж, хэрэглэгчийг шилжүүлж бүрэн дууссан.



Тоон телевизийн өргөтгөл


Баян-Өлгий аймгийн 4 сум, Баянхонгор, Ховд, Сүхбаатар, Багануур аймгуудад тоон телевизийн сүлжээ байгуулах техникийн даалгаварыг боловсруулж, суурилуулалт бүрэн хийгдэж, хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлж эхлээд байна.

- 2019 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны гүйцэтгэл
- **Хувьцаа эзэмшигчдийн хурал**
- Төлөөлөн удирдах зөвлөл
- Ногдол ашгийн тухай

Компанийн хувьцааны тухай

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй Монголын цахилгаан холбоо ХК-ийн нийт хувьцааны 94.7 хувь буюу 24,499,287 ширхэг хувьцааг Монгол Улсын Засгийн газар, 5.3 хувь буюу 1,370,989 ширхэг хувьцааг Монгол Улсын болон гадаадын иргэн, хуулийн этгээд тус тус эзэмшиж байна.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД



НИЙТ ХУВЬЦААНЫ
ТОО

25,870,276

НИЙТ ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧИЙН ТОО

3,955

Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч



Нэр:

Монгол Улсын Засгийн Газар

Эзэмшиж буй хувьцааны тоо:
24,499,287

Эзэмшиж буй хувьцааны хувь:
94.7



Монголын цахилгаан холбоо ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2019 оны ээлжит хурал 2019 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 11:00-14:00 цагийн хооронд компанийн төв байрны хурлын зааланд зохион байгуулагдлаа.

2019 оны 4 дүгээр сарын 03-ны өдрөөр тасалбар болгон бүртгэсэн 25,870,276.0 ширхэг хувьцаа эзэмшиж буй 3955 хувьцаа эзэмшигчдээс 24,048,640 ширхэг саналын эрх бүхий 22 хувьцаа эзэмшигч оролцож хурлын ирц 96.82 хувьтай байлаа.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн асуудлууд

- Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай
- Компанийн 2018 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах тухай
- ТУЗ-ийн Аудитын хорооны санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг батлах тухай
- ТУЗ-ийн 2019 оны зардлын төсвийг батлах тухай
- Ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн шийдвэрийн үндэслэлийг танилцуулах тухай

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гаргасан шийдвэрүүд

- Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийсэн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай асуудлыг 97.83 хувийн саналаар батлав.
- Компанийн 2018 оны санхүүгийн тайлан, түүнд хийсэн хараат бус аудитын тайлан дүгнэлтийг батлах тухай асуудлыг 97.83 хувийн саналаар батлав.
- ТУЗ-ийн Аудитын хорооны санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг батлах тухай асуудлыг 97.83 хувийн саналаар батлав.
- ТУЗ-ийн 2019 оны зардлын төсвийг батлах тухай асуудлыг 99.99 хувийн саналаар батлав.

- 2019 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны гүйцэтгэл
- Хувьцаа эзэмшигчдийн хурал
- Төлөөлөн удирдах зөвлөл
- Ногдол ашгийн тухай

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд

Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй, тэдгээрийн гуравны нэг (1/3) нь хараат бус гишүүн бөгөөд ердийн 6 гишүүн нь төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлдэг.

Төлөөлөн удирдах зөвлөл нь гурван дэд хороотой, хороо тус бүр 3 хүний бүрэлдэхүүнтэй. Үүнд:

- Аудитын хороо,
- Нэр дэвшүүлэх хороо,
- Цалин, урамшууллын хороо

2019 оны эхний хагас жилд Төлөөлөн удирдах зөвлөлийн 4 удаагийн хурлаар 14 асуудал хэлэлцэж 11 шийдвэр, 2 тэмдэглэл гаргасан байна.



Ц.БАЯР-ЭРДЭНЭ
ТУЗ-ийн ДАРГА
НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ ДАРГА



Ж.ЦОГТБАЯР
ТУЗ-ийн ЕРДИЙН ГИШҮҮН
АУДИТЫН ХОРООНЫ ГИШҮҮН



Т.ЛХАГВАСҮРЭН
ТУЗ-ийн ЕРДИЙН ГИШҮҮН



Д.АРИУНТУЯА
ТУЗ-ийн ЕРДИЙН ГИШҮҮН
Цалин, урамшууллын
ХОРООНЫ ДАРГА



Ч.ЦЭВЭГДОРЖ
ТУЗ-ийн ЕРДИЙН ГИШҮҮН



Г.ЭРДЭНЭБУЛГАН
ТУЗ-ийн ЕРДИЙН ГИШҮҮН



Ц.НОРОВЖАМЦ
ТУЗ-ийн ХАРААТ БУС ГИШҮҮН
Аудитын хорооны ДАРГА
НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ ГИШҮҮН



Л.БОЛОРМАА
ТУЗ-ийн ХАРААТ БУС ГИШҮҮН
Цалин, урамшууллын
ХОРООНЫ ГИШҮҮН
Аудитын хорооны ГИШҮҮН



Ж.ТАМИР
ТУЗ-ийн ХАРААТ БУС ГИШҮҮН
Цалин, урамшууллын хорооны
ГИШҮҮН
НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ ГИШҮҮН

- 2019 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны гүйцэтгэл
- Хувьцаа эзэмшигчдийн хурал
- Төлөөлөн удирдах зөвлөл
- Ногдол ашгийн тухай

Ногдол ашгийн тухай

Монголын цахилгаан холбоо ХК нь Компанийн тухай хуулийн дагуу болон компанийн дүрмийн дагуу компанийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахдаа дараах нөхцлийг биелүүлсний дараа хуваарилдаг. Үүнд:

- Ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх;
- Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь хуульд заасан доод хэмжээнээс их байх;
- Компани эргүүлэн авах үүрэгтэй хувьцааг бүрэн авсан байх;

Дараах шалтгаануудын улмаас 2018 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахгүй байхаар МЦХ ХК-ийн ТУЗ-өөс шийдвэрлэсэн.

Үүнд:

- Компанийн төлбөрийн болон хөрвөх чадварын харьцааны үзүүлэлтүүд буурах хандлагатай байгаа.
- 2018 оны хөрөнгө оруулалтын төслүүдийг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг хадгалах шаардлага тулгарсан.

Ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн шийдвэрийн үндэслэлийг 2019 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар танилцуулсан.

